



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/123

Бат-Өлзий сум

Газар түр ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хужирт-Бат-Өлзий чиглэлийн хатуу хучилттай 49 км авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан "Мотор сервис" хязгаарлагдмал хариуцлагатай компанид замын барилга байгууламжийг гүйцэтгэх хугацаанд бетон зуурмагийн үйлдвэрийн зориулалтаар $46^{\circ}51'53.3"N$ $102^{\circ}18'31,9"E$, $46^{\circ}51'53,3"N$ $102^{\circ}18'34,8"E$, $46^{\circ}51'51,1"N$ $102^{\circ}18'34,6"E$, $46^{\circ}51'51,2"N$ $102^{\circ}18'32,3"E$ байршилд газрыг түр хугацаагаар ашиглуулсугай.

2. "Мотор сервис" хязгаарлагдмал хариуцлагатай компанид түр хугацаагаар ашиглуулах хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны улсын хяналтын байцаагч (Б.Янжиндулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН